



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/283

Арвайхээр сум

Г Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 23/14 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтын 3 дугаарт батлагдсан нийтийн эзэмшилийн зам талбай, гэр хорооллын айл өрхүүдэд эко ариун цэврийн байгууламж байгуулах 532,800,000 (таван зуун гучин хоёр сая найман зуун мянга) төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Арвайхээр сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлганахыг Арвайхээр сумын Засаг даргад үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН



6224 11 0582

D:My Doc. Zahiramj. Zasag darga